

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Замын-Үүд чөлөөт бүс

Албан тушаалын нэр:

Захирагч

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Захирагчийн ажлын алба

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Эрхэлсэн түшмэл, ТЗ-2

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн
Үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах, экспорт, импортыг дэмжих, хөрөнгө оруулалт татах, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, аялал жуулчлал, тээвэр логистикийн зохистой харьцаа бүхий хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, мэргэжлийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах чиг үүргийн хүрээнд ажлын албыг мэргэшлийн үндсэн дээр удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

- 1.Чөлөөт бүсийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшлийн үндсэн дээр удирдан зохион байгуулах.
2. Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах.
- 3.Чөлөөт бүсийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх.
- 4.Чөлөөт бүсийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх.
- 5.Чөлөөт бүсийн гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
- 6.Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх, Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Чөлөөт бүсийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангах, бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангах;	Чөлөөт бүсийн ажлын албыг мэргэшсэн, тогтвортой байлгаж, нэгдмэл бодлого, удирдлагаар хангагдсан, үйл ажиллагааны зохион байгуулалт шуурхай бөгөөд сайжирсан байна.	Г, Х, Ш
	2.Байгууллагын хэмжээнд мөрдөх дүрэм, журам зааврыг хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн баталж мөрдүүлэх;	Дүрэм, журам заавар нь хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х, Ш
	3.Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн захиргааны төв, Нутгийн захиргааны байгууллага, хөрөнгө оруулагч иргэд, байгууллагаас чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хууль тогтоомжийн дагуу үнэлгээ өгөх, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр удирдлагыг хангах;	Удирдлагыг цаг үеэ олсон шуурхай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангасан байна.	Г, Х, Ш
	4.Чөлөөт бүсийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж, шийдвэр гаргах.	Холбогдох захирамж, шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомж, үйл ажиллагааны хөтөлбөр, шийдвэрийг хэрэгжүүлэх бодлого тодорхойлоход	Холбогдох асуудлаар төсвийн ерөнхийлөн захирагчийг шаардлагатай шуурхай зөвлөгөө	Г, Х

	Төсвийн ерөнхийлөн захирагчийг шаардлагатай шуурхай зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах;	дэмжлэгээр хангасан байна.	
	2.Хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээний асуудал, чөлөөт бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, чөлөөт бүсийн дэд бүтцийг өргөжүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтыг хариуцах, хяналт тавих, албаны хэвийн үйл ажиллагааг хангах;	Чөлөөт бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөтөлбөр хэрэгжсэн, чөлөөт бүсийн дэд бүтцийг өргөжүүлэх, бүтээн байгуулалтын чиглэлээр зохион байгуулсан ажил, үйлчилгээ үр дүнд хүрсэн байна.	Г, Х
	3.Холбогдох хууль тогтоомж Засгийн газар болон чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах;	Шийдвэрүүд хэрэгжсэн байна.	Г, Х
	4.Эрх хэмжээнийхээ хүрээнд чөлөөт бүсэд дагаж мөрдөх дүрэм, журам заавар баталж мөрдүүлэх, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих, хуульд өөрөөр заагаагүй бол холбогдох яамд, мэргэжлийн байгууллага, аймаг сумын Засаг дарга, түүний Тамгын газар, хөрөнгө оруулагчдад хариуцсан асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;	Хууль тогтоомжийн дагуу хийгдэж хэрэгжсэн байна.	Г, Х, Ш
	5.Чөлөөт бүсийг төлөөлж бусад байгууллагатай харилцах, гэрээ хэлцэл хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Гэрээ хэлцэл хуульд нийцсэн, хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хийгдсэн байна.	Г, Х, Ш
	1.Чөлөөт бүсийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнах;	Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнасан байна.	Г, Ш
	2.Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлт, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аудитын байгууллагаас	Мэдээ тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд нь тайлагнасан байна.	Г, Х

3 дугаар зорилтын хүрээнд	шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргах;		
	3.Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Чөлөөт бүсийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоолгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх;	Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, бүтээмж дээшилсэн, чиг үүргийн давхардал арилсан, ажлын ачаалал нягтарсан байна.	Х, Т
	4.Чөлөөт бүсийн үйл ажиллагааг өргөжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр гадаад дотоодын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санал санаачилга гаргаж, Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан хэрэгжүүлэх;	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо өсөж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх нөхцөл бүрдсэн байна.	Г, Х, Ш
	5.Дотоод хяналт шалгалт, аудитыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.	Дотоод аудит, хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Албан хаагчид мэргэшлийн өндөр чадвартай байх, байгууллагын соёл, ёс зүйн эрхэмлэх зүйлийг хэвшүүлэх;	Байгууллагын соёлыг дээдэлсэн, ёс зүйн зөрчилгүй хамт олон бүрдсэн байна.	Г, Х, Ш
	2.Албан хаагчийг томилох, чөлөөлөх, сэлгэн ажиллуулах, үр дүнгийн гэрээ байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлж дүгнэх;	Хүний нөөцтэй холбоотой аливаа шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х, Ш
	3.Албан хаагчдын ажлын үр дүнтэй уялдуулан шагнаж урамшуулах, зэрэг дэв олгох, хариуцлага тооцох, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах;	Албан хаагчдын идэвх, хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн байна.	Г, Х, Ш
	4.Байгууллагын өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх тэдгээрийг давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх ажлыг бодлого, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах;	Шаардлагатай мэргэжлийн бэлтгэгдсэн хүний нөөцөөр хангагдсан байна.	Г, Х, Ш
	5.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах.	Албан хаагчид шаардлагатай нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	Г, Х, Ш

5 дүгээр зорилтын хүрээнд	1. Замын-Үүд чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө, боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;	Төлөвлөгөө нь үндэсний язгуур эрх ашигт нийцсэн, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан, судалгаа тооцоо болон бодит нөөц бололцоонд үндэслэн боловсруулагдсан байна.	Г, Х, Ш
	2.Хариуцсан асуудлын хүрээнд тухайн жилийн Төсвийн тухай хуульд хэрэгжүүлэхээр заасан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тусгасан гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь Мастер төлөвлөгөө болон бодлогын баримт бичигтэй уялдсан, зорилт, шалгуур үзүүлэлтэд нийцсэн байна.	Г, Х, Ш
	3.Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түшингийн үнэлгээг үндэслэн хүний нөөцийн шагнал урамшуулал, зэрэг дэв, албан тушаал ахиулах, сургалтад хамруулах, хариуцлага, шийтгэл оногдуулах асуудлыг шийдвэрлэж хэвшүүлэх;	Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин зохих журмын дагуу үнэлэгдэж хэвшсэн, холбогдох шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х, Ш
	4.Эрсдэлийн менежмент-Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31010:2016, Эрсдэлийн менежмент-Зарчим ба заавар MNS ISO 31000:2011 Монгол Улсын стандартыг хэрэгжүүлэх, хяналт тавих.	Эрсдэлийн менежментийн стандартыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
6 дүгээр зорилтын хүрээнд	1.Төсвийн ерөнхийлөн захирагчаас өгсөн үүрэг даалгавар болон хууль тогтоомжийн дагуу шилжүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;	Цаг үеийн шинжтэй ажлууд шуурхай, үр дүнтэй, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдсэн байна.	Т, Г
	2.Чөлөөт бүсийн асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн болон холбогдох хөтөлбөр, арга хэмжээний төсөлд санал өгөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.	Санал нь хуульд нийцсэн, судалгаа, нотолгоонд үндэслэн цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэг хамгаалсан.		

Мэргэжил	- Эдийн засаг /0311/; - менежмент ба удирдахуй /0413/; - эрх зүй /0421/; - олон улсын эдийн засгийн харилцаа /038801/; - барилгын инженерчлэл /073204/.	
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 8-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- хөгжлийн бодлого төлөвлөлтийн дагуу тухайн салбарын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; - чөлөөт бүсийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх; - эрхэлсэн ажлын хүрээнд албан хаагчдыг холбогдох мэдээллээр ханган, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих, зохих заавар, зөвлөмжөөр хангах; - эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах; - төр засгийн бодлогыг чөлөөт бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг хариуцлага хүлээх; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- чөлөөт бүсийн талаарх мэдээлэлд тулгуурлан системийн шинжилгээ хийх; - байгууллагын мандах/ чиг үүрэг/-ын шинжилгээ, гадаад болон дотоод орчны шинжилгээ хийх; - чөлөөт бүсийн бодлого, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд санал, зөвлөмж өгөх; - чөлөөт бүсийн бодлогын судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлэх; - чөлөөт бүс дэх нарийн төвөгтэй, эргэлзээтэй асуудлыг бодитоор үнэлж дүгнэх; - шийдвэрийн үр дагаврыг тооцоолж, болзошгүй эрсдэл түүнийг давах шийдлийг зөвлөдөг байх; - асуудал, санал боловсруулахдаа дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ, харьцуулсан судалгаанд үндэслэдэг байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- аливаа асуудлыг албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг олон талаас нь олон хувилбараар хардаг байх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - өөрийн болон доод албан тушаалтны гаргасан шийдвэрийн хариуцлагыг үүрэх үр дагаврыг хариуцах;

		- бусад.
	Манлайлах	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - чөлөөт бүсийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - ажил хэргийн хувьд зарчимч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд үлгэр дуурайлал үзүүлэх; - Төрийн албаны болон байгууллагын шинэчлэлт, өөрчлөлтийг удирдан манлайлах; - албан хаагчид, оролцогч талууд, хамтрагчидтай хүндэтгэлтэй, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч адил тэгш харилцдаг байх; - албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, үлгэрлэн манлайлах; - нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
	Бусад	- хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэх; - технологийн шинэ эрин үе дэх хөгжлийн бодлого, технологийн инновац удирдлагыг хэрэгжүүлэх; - чөлөөт бүсэд цахим үйлчилгээ, шинэ арга барилыг нэвтрүүлэх; - чөлөөт бүсийн оролцогч талуудын олон талт байдлыг зохицуулах; - англи болон хятад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - чөлөөт бүсэд мэдээллийг шуурхай солилцох соёл төлөвшүүлэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>	<u>Бусад харилцах субъект:</u>
Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд. <u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> - Захирагчийн ажлын албаны дарга -1 - Нэгжийн дарга -6 - Мэргэжилтэн -24 - Ерөнхий нягтлан бодогч -1 - Тооцооны нягтлан бодогч -1 - Эдийн засагч -1 - Захирагчийн туслах -1 - Бичиг хэргийн ажилтан -1 - Архивын ажилтан -1 - Нярав -1 - Туслах ажилтан -3 Нийт: 41	- Эдийн засаг, хөгжлийн яамны хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газар; - Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан; - Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагын холбогдох албан тушаалтан; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн ажилтан; - Чөлөөт бүсэд хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн холбогдох ажилтан; /гадаад, дотоодын/; - "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Хятадын талын эрх бүхий байгууллага;

	албан тушаалтан; - Иргэн, хуулийн этгээд.
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга  Б.Дашпүрэв 2023 оны 04 дугаар сарын 07-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 23 04 07 <u>Дугаар:</u> 102
<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</u>	
Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: 2023.04.07 Дугаар: ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН САЙД (Газрын үсэг)  Ч.ХҮРЭЛБААТАР (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр) 2023 оны 04 дугаар сарын 07-ны өдөр	

